

Такашима арлын орчмоос олдсон Юаний флотын зарим олдворыг Хархорум хот ба Монголын үеийн булшны олдворуудтай харьцуулах нь

Уламбаярын Эрдэнэбат^{1,*}

Товч агуулга: Монголын Их Юань улс 1274, 1281 онуудад Японд хоёр удаа халдан довтолсон боловч далайн хар шуурганд автаж сүйрсэн билээ. Хубилай хааны илгээсэн хэдэн зуун хөлөг онгоц Хаката булангийн Такашима арлын орчим далайд живжээ. Японы археологичид 1980-аад оноос Такашима орчим усан доорх археологийн системтэй судалгаа хийж судалгааны тайланг удаа дараа нийтлүүлсэн байна. Эдгээр бүтээлд Юаний флот Японд довтолсон түүхэнд холбогдох олон сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүнүүд гарсны дунд 13-14 дүгээр зууны монголчуудын эд өлгийн дурсгалтай харьцуулж болохуйц зарим олдворыг сонгон авч энэхүү өгүүлэлд ашиглав. Үүнээс үзэхэд Юаний флотын олдворууд дунд Монголоос олддог, агсарга бүс, эмээлийн чимэглэл, шор, малгайн чимэглэл зэрэг нүүдэлчдийн онцлогтой олдворууд цөөнгүй байна.

Түлхүүр үг: Монголын эзэнт гүрэн, Юань улс, Хубилай хаан, Монголчууд Япон улсад довтолсон нь, Такашима, Хархорум, Монголын үеийн булшны олдвор

Монголын Их Юань улс 1274, 1281 онуудад Японд халдан довтолсон боловч далайн хар шуурганд автаж сүйрсэн билээ. Хубилай хааны илгээсэн хэдэн зуун хөлөг онгоц Хаката булангийн Такашима арлын орчим далайд живжээ. Японы археологичид 1980-аад оноос Такашима орчим усан доорх археологийн системтэй судалгаа хийж судалгааны тайланг удаа дараа нийтлүүлсэн байна (Ikeda 2011). Эдгээр бүтээлд Юаний флот Японд довтолсон түүхэнд холбогдох олон сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүнүүд гарсны дунд 13-14 дүгээр зууны монголчуудын эд өлгийн дурсгалтай харьцуулж болохуйц зарим олдворыг сонгон авч энэхүү өгүүлэлд ашиглалаа.

Тус өгүүллийн зохиогч 2010 оны 10 дугаар сард болон 2024 оны 3 дугаар сард Такашима дахь Юань гүрний довтолгооны түүхийн музейд зочилж зарим олдворыг нүдээр үзэх завшаан олдсон юм. Музейд хамгийн түрүүн нүднээ туссан олдворууд бол Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотоос элбэг олддог Юань улсын үеийн шаазангийн хагархай, төрөл бүрийн вааран савнууд байлаа. Хархорум хотыг малтахад төрөл бүрийн шаазан вааран савны хагархай хэлтэрхий хэдэн зуугаараа үе давхарга бүхнээс илрэн гардаг. Тэдний ихэнх нь Хятадын технологийн уламжлалын дагуу бүтээгдсэн байдаг. Тухайлбал, хамгийн элбэг нь цагаан өнгийн паалантай “дин”, “цычжоу”, хөхөвтөр ба улаавтар өнгөтэй “цзюнь”,

цэгээн өнгийн “чинбай” зэрэг байх бөгөөд Юань улсын алдарт хөх цагаан “ченхуа”, селадоны төрлийн шаазангууд болох ногоон паалантай “лунцюань”, “рү” тэргүүтэн, өөр технологиор бүтсэн сав суулгын зүйл төрөл төрлөөрөө илрэн гарахын зэрэгцээ исламын урлагийн шинж чанарыг хадгалсан сав суулгын үлдэгдэл ч олддог билээ. Түүний зэрэгцээ орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох сайн шатааж хийсэн хар саарал өнгийн шавар сав суулга гардаг юм (Эрдэнэбат 2018). Харин Такашимагийн музейд байгаа далайн ёроолоос малтаж гаргасан шаазан сав суулгууд нь Хятад, Солонгос гаралтай байна. Хархорум хотоос олддогтой яг ижил сэтэлж хаясан далны яс, ташиж хугалсан чөмөг, хятад зооснууд, чулуун янтай, жингийн туухай зэрэг зүйлс байсныг энд ярихгүй.

Бид энэхүү нийтлэлдээ юуны өмнө Такашима орчмоос олдсон Юаний цэргийн бүс, эмээлийн чимэглэл, шор, малгайн чимэглэл зэрэг нүүдэлчдийн онцлогтой цөөн хэдэн олдвор дээр тогтож ярихыг хүсч байна.

Бүс бол нүүдэлчин ард түмний хувцасны соёлд нэн чухал байр эзэлдэг. Энэ нь тэдний өдөр тутмын амьдрал ахуйн онцлогтой холбоотой. Цаг агаарын хүйтэн сэрүүн нөхцөлд жавар салхинаас хамгаалж биеийнхээ дулааныг хадгалахад дээл хувцсаа заавал бүсэлж явах шаардлагатай. Түүнээс гадна чөдөр, ногт, хутга, хэт цахиур зэрэг хөдөлмөрийн багаж зэвсгийн зүйлсийг гарын дор бэлэн авч явахад бүс зайлшгүй хэрэгтэй байдаг. Аян дайнд мордсон цэрэг эрс илд сэлэм, саадаг хоромсогоо бүсэндээ зүүж агсдаг

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим, Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: u_erdenebat@num.edu.mn
<https://orcid.org/0000-0003-0867-3691>

байжээ. Тиймээс монголчууд эрт дээр үеэс “агсарга” хэмээх суран бүс өргөн хэрэглэж зэс, хүрэл, алт, мөнгө, эрдэнийн чулуун товруугаар гоёж чимэглэдэг байжээ. Тал нутгийн дайчин эрсийн амьдралд бүс нэн чухал хэрэгцээт эдлэл байсан нь улмаар бүсийг хүч чадал, эрх мэдлийг илтгэх бэлгэ тэмдэг хэмээн биширч хүндлэх шүтлэгийн агуулгатай болгожээ.

Дундад зууны монголчууд мөнгөн товруутай агсарга бүс хамгийн өргөн хэрэглэж байсан юм. Иймээс Монголд болон хилийн чинадад малтан судалсан Монголын үеийн жирийн иргэдийн булш оршуулгаас цөөнгүй олддог. Эдгээр бүсний нэлээд нь цэцгэн хэлбэртэй толь, тал саран болон дүгрэг, цэцгэн хэлбэрийн товруутай байдаг нь Монголын үеийн хүн чулуун хөшөө, уран зургийн дурсгалуудад дүрсэлсэн бүсний хэлбэр, бүтэцтэй тохирч байдаг.

Такашима арлын музейд байгаа бүсний чимэглэлүүд нь зэсийн хайлш буюу хүрлээр хийсэн байгаа нь зэрэг дэсийн хувьд тийм ч өндөр хүнийх биш юм. Хүрлээр хийсэн бүсний бэл нь дөрвөн дэлбээтэй цэцгэн хэлбэртэй, нүүрэн талдаа цохимол хээтэй, доод талдаа хавтага бэхлэх зууван дугуй сэнжтэй, дундуураа тэлээний сур гүйлгэх нэвт нүхтэй, голдоо хөндий, хоёр хэсгээс бүрдэх ажээ (Зураг 1 : 12, 13). Мөн гурван өнцөгтэй, нэг талдаа сур гүйлгэх нүхтэй, их биен дээрээ хадаас хадах нүхтэй, ар талдаа хоёр даравчтай чимэглэлүүд бий (Ikeda 2011: 60). Түүнчлэн агсарга бүсэн дээр хадаж байсан цоолбор хээтэй хэд хэдэн төрлийн чимэглэлүүд, зарим нь агсарга бүсний унжлаганы үзүүрийн чимэглэлүүд байна (Зураг 4). Бүсний арал нь зууван дугуй хэлбэртэй, иржгэр биетэй, нарийн богино хэлтэй, нимгэн зууван шахуургатай, тэлээний суранд 3 хадаасаар хадаж тогтоодог байжээ (Хавсралт зураг 1-1, 2).

Такашима орчмоос олдсон дээрх бүсний чимэглэлүүд нь хэв загварын хувьд 13-14 дүгээр зууны монголчуудын бүстэй тун адилхан юм. Тухайлбал, Монгол Улсын Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Бухын хошуу (Зураг 5), Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уул (Зураг 2) зэрэг газар судалсан 13-14 дүгээр зууны монгол булшнаас үүнтэй төстэй бүсний алт шармал, хүрэл чимэглэлүүд олдсон байна (Erdenebat 2009: 118; Амартүвшин нар 2015: 288, 289, 294, 304). Мөн Улаанбаатар хотноо хувийн цуглуулагчид байгаа Монголын эзэнт гүрний үеийн мөнгөн бүсний чимэглэл (Зураг 3) нь Такашимагийн музейд байгаа бүсний бэлтэй ижил төрөл юм. Улаанбаатарт байгаа бүсний хэсгүүд суран оосрын тасархай бүхий хавтага бэхлэх зориулалттай сэнжтэй хоёр, сэнжгүй нэг, тал саран хэлбэртэй хоёр ширхэг товруунаас бүрдэж байна. Дугуй товруу нь бадам цэцгийн найман дэлбээг товойлгосон хүрээтэй, голын дугуй тойрогт багтаан толгойгоо гэдрэг эргүүлсэн ганц эвэртэй гөрөөс

дүрсэлсэн. Тал саран хэлбэрийн товруу нь нүүрэн талдаа бадам цэцгийн дөрвөн дэлбээтэй нь бэлгэт гөрөөсийн дүрстэй товрууныхтай ижил байдаг.

Нүүдэлчдийн хувцас эдлэлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох бүсний талаар ярихад зайлшгүй хамтад нь авч үзэх шаардлагатай зүйл бол бүснээс зүүж явдаг хавтага сав, хэт хутга зэрэг эдлэл болно. Монголчуудын чулуун хөрөг, Юань улсын үеийн уран зураг болон перс миниатюрт хавтага зүүсэн монгол эрчүүдийг дүрсэлсэн байдлаас харахад, зүүн ташаандаа хэмжээгээр нэлээд том, дөрвөлжин хэлбэртэй хавтага, баруун ташаандаа үүнээс жижиг хэмжээтэй, мөлгөр булантай хавтага зүүсэн байх бөгөөд хавтагын цаагуур урт шулуун буюу махир хэлбэртэй хутга, сэтгүүр мэт зүйлс цухуйж буй байдлаар гаргасан байдаг. Такашима орчмоос малтаж гаргасан олдворуудын дунд бүснээс зүүж явах оосор зүүх нүх гаргасан эврээр хийсэн хоёр шор (Зураг 13: 1) байгаа (Matsuura 2011: 205) нь Монголын нүүдэлч малчдын чөдөр, ногт зэрэг суран эдлэлийн зангилаа гаргахдаа хэрэглэдэг шор /ихэвчлэн буга, гурын эврээр хийдэг/ мөн болно. Ийм шор эртний судлалын малтлагаас нэг бус удаа олдож байсан (Зураг 13: 2) төдийгүй Ляо улсын хятан бунхны ханын зураг (Tori 1942: 1), Монголын эзэнт гүрний хүн чулуун хөргүүдэд бүснээс зүүлгэн дүрсэлсэн (Зураг 12) байдаг билээ.

Такашима арлын орчмоос олдсон жижиг хэмжээтэй хүрэл арал болон оломнууд бүгдээрээ бүснийх биш, бас морины эмээлийн ганзаганы оосор, хударга, хөмөлдөрөгний сур бэхлэх гогцоо байсан байж болох юм. Тухайлбал, Такашимагийн зарим олдвор (Ikeda 2011: 63.2-3) 2007 онд Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойд малтсан 13-14 дүгээр зууны монгол булшнаас гарсан эмээлийн сур бэхлэх оломны хэсгүүдтэй (Зураг 6) тун адил байна. Түүнээс гадна Такашима орчмоос олдсон хэмжээгээр том хонхнууд нь морины хударга, хөмөлдөргийн чимэглэл (Зураг 7-8), хэмжээгээр жижиг нь сургаж тэжээсэн харцага, шонхорын хөлнөөс уядаг хонхтой ойролцоо байгааг хэлэх хэрэгтэй.

Такашима арлын орчим далайгаас олдсон өөр нэг сонирхолтой олдвор бол хөөмөлдөх аргаар хийсэн цэцэг ургамлын хээ бүхий ялтаснууд (Зураг 9: 16-17) бөгөөд энэ нь мөн л монголчуудын агт морины эмээлийн хударга хөмөлдөргийн чимэглэлтэй холбоотой ажээ. Такашимагийн ийм олдвортой төстэй хэрэглэгдэхүүн Лондон хотноо Насир Халилийн цуглуулга (Зураг 10), Улаанбаатар хотноо хувийн цуглуулагчид (Зураг 11) байгаа Монголын эзэнт гүрний алтан эмээлийн хударганы чимэглэлийн дотор харагдаж байна (Komaroff, Carboni 2002: 17, fig. 10, Cat. No. 141). Эдгээр зэмсгийн хэлбэр дүрс ялигүй зөрүүтэй ч хийсэн арга барил, үүргийн хувьд ижил юм. Нимгэн ялтсыг хөөмөлдөн цохиж тэгш суурьтай

цэцгэн хэлбэртэй дүрс гаргаж, гол төвд нь дугуй хэлбэртэй нүх гаргаж орхисон. Чимэглэлийн захыг цулгүй зурвас гарган хүрээлж түүний доторх дүрсийг зээг мэт иржгэр зурвасаар хүрээлдэг. Цэцгийн дэлбээг голлуулан зохих хээ угалзыг тэгш хэмтэй цохиж гаргасан. Ялангуяа хээ дүрсийг нүүдэлчин үндэсний онцлогтой зээгээр хүрээлдэг нь 13-14 дүгээр зууны монгол дархны хийцэд нийтлэг байдаг шинж болно.

Такашимагийн музейд байгаа өөр нэг сонирхолтой олдвор нь монголчуудын хувцастай холбоотой, малгайнхаа орой дээр хадаж байсан хаш чулуугаар хийсэн бололтой жинс (Зураг 14) юм (Matsuura 2011: 204). Үүнтэй ижил төрлийн олдвор Монголын эртний нийслэл Хархорум хотын гудамжны уулзварын барилгад 1949 онд Монгол-Зөвлөлтийн археологичдын хийсэн малтлагаас гарч байжээ (Киселев 1965: 288, Рис. 148). Эндээс тогоруу шувуу болон согооны дүрс сийлсэн, юман дээр хадаж тогтоох нүх бүхий 4 x 2,3 см хэмжээтэй хоёр чулуун эдлэл олдсон юм (Зураг 15). Хашаар сийлсэн бэлгэ дэмбэрэлтэй амьтны дүрс бүхий чулуун жинс нь малгайнхаа хамт бүрэн бүтэн хадгалагдсан олдворууд (Зураг 16) БНХАУ-ын зарим хувийн цуглуулагчийн гарт байдаг ажээ (Feng & Lin 2005: 69).

Такашимагийн музейг үзэж явахад мэдээж хэрэг Юань гүрний цэргийн нум, харвуулын сумны багц зэвүүд, төмөр илд, бүтэн хөө хуяг анхаарал татаж байлаа (Зураг 17, 20, 22). Илдний тухай ярихад, дундад зууны монголчууд нэг талдаа иртэй, шулуун урт төмөр илд хэрэглэж байсан нь олон төрлийн баримтаар мэдэгдэх бөгөөд Такашима орчмоос олдсон олдвор нь монгол цэргийн илдтэй адил байна. (Зураг 19). Монгол Улсын Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Арцат дэл хэмээх газраас 10-11 дүгээр зуунд холбогдох, бүснээс зүүх төмөр оосор, сурны үлдэгдэл бүхий бүрэн бүтэн хадгалагдсан модон хуйтай төмөр илд (Зураг 18) олдсон юм (Erdenebat 2009: 447). Сонирхолтой нь Монголын хадны оршуулгын нэгэн адил далай доор усанд байсан зарим төрлийн олдворууд маш сайн хадгалагдсан, түүнийг Японы сэргээн засварлагч, хадгалалт хамгаалалтын мэргэжилтнүүд гайхалтай сайхан хамгаалж чаджээ.

Монгол нум нь эвэр элэгтэй, шөрмөс орхин бэхэлсэн зүймэл нум бөгөөд археологийн малтлага судалгаагаар, ялангуяа Монгол орны хуурай сэрүүн агуй, хадны хонгилд хийсэн эртний оршуулгуудаас бүтэн бүтэн байдлаар цөөнгүй олдсон байдаг. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Хагт уулнаас хөвчтэйгөө хамт хадгалагдсан, 13 дугаар зууны бүтэн нум, дотроо багц сумтай үйсэн саадагтайгаа олдсон юм (Амартүвшин, Батдалай 2020: 117). Мод, эвэр, шөрмөс, үйсээр урлаж чий будгаар будсан энэхүү нумын гичир нь 30 см, элэгний наалт 30 см, гуравч буюу бариул нь 12 см урт болно (Зураг

21). Харвуулын сумны зэв олон төрөл, тус тусдаа өөр зориулалттай тул сумны үзүүрийг харж байж сонгож харвадаг. Тиймээс сумаа сонгон авахад хялбар байдлаар үзүүрийг нь дээш харуулан саадгандаа багцлан хийдэг байжээ (Зураг 23). Баян-Өлгий аймгийн Хагт гэдэг газраас олдсон саадган дотор үзүүрийг нь дээш харуулан дүрсэн 7 өөр төрлийн сум байсан бол Баянхонгорын Арцат дэлийн дүрсгалд 19 сум саадган дотор багцаараа байжээ. Хагтын саадагны ерөнхий хэлбэр, мөн үйсэн бортогыг бэхэлж сураар даруулан үдсэн гурван салаа сэрээ хэлбэртэй нарийн савх модон чимэг нь дундад зууны монголчуудыг дүрсэлсэн перс номын чимэглэл зурагт олонтаа дүрсэлсэнтэй яг адилхан байдаг (Зураг 19).

Дундад зууны монголчууд дорно дахины бусад ард түмний нэгэн адил гээг үсээ засч янзлах нэгэнт тогтсон хэв заншилтай байсан билээ. Монголчууд зулай дээрээ гөхөл хэмээх хэсэг үс үлдээж тойруулан хусаад шанаа болон ар дагзны үсийг хэвээр орхин үүнээсээ шибилгэр хэмээх хоёр салаа гээг гөрж, тус бүрийг чихний араар багцлан унжуулдаг байсан онцлог засалтай байжээ. Тиймээс Монголын үеийн булш оршуулгыг малтан судлахад ерөнхийдөө эмэгтэй хүний оршуулганд сам дагуулан тавих боловч бас эрэгтэй хүнийхээс ч сам олддог юм. Гэхдээ оршуулганд сам тавихдаа эмэгтэй, эрэгтэй ялгалгүй бараг ихэнх тохиолдолд хугалж тавьсан зан үйлийн онцлог мэдэгддэг. Тэр үеийн эгэл жирийн хүмүүсийн хэрэглэж байсан самыг үзвэл ихэвчлэн мод юмуу ясаар хийдэг байжээ. Такашима орчмоос далайгаас гаргасан Юаний флотын олдворууд дунд гоо сайхны хэрэгсэл сам нь чухал суурь эзлэх бөгөөд Монголоос олдсон олдворуудтай ялгах юмгүй ижилхэн байна (Зураг 24).

Такашима дахь Юаний довтолгооны түүхийн музейн хамгийн сонирхол татсан үзмэр бол яах аргагүй Хубилай хааны зарлигаар Төвдийн Пагва ламын зохиосон дөрвөлжин үсэгтэй тамганы хуулбар байлаа. Уг тамга Такашима арлын эрэг орчим хайрцагтайгаа унасан байсныг арлын оршин суугч нэгэн хүн олж хадгалж байгаад эрдэмтэн судлаачдад авчирч өгсөн түүхтэй ажээ (Matsuura 2011: 42). Тамганы жинхэнэ эхийг Такашима арлын захирагчийн өргөөнд хадгалж байдаг. Такашима орчмоос олдсон энэхүү хүрэл тамгыг зуугын даргаас дээш зиндааны цэргийн эрхтэн эзэмшиж байсан болов уу гэж үздэг (Зураг 25). Бичээс нь “Нэг зуугаас мянган цэргийн захирагч” хэмээн уншигдах бөгөөд тамганы ар талд “Жи Юаний 14 дүгээр он” гэжээ. Энэ нь Хубилайн хаанчлалын үе тодруулбал 1277 онтой дүйнэ. Их Юань гүрэн Япон улсын эсрэг анхны довтолгооноо 1274 онд хийсэн тул тамганы эзэн хоёр дахь довтолгооны үеэр буюу 1281 онд амь үрэгдсэн ажээ.

Такашима арлаас олдсонтой хэлбэр загварын хувьд ялгах юмгүй ижил хүрэл тамга Монголын

эртний нийслэл Хархорум хотыг малтан судлах явцад бас олдсон юм (Зураг 26). Хархорумын тамга нь дөрвөлжин ултай, орой руугаа шувтан хэлбэрийн гонзгой бариултай. Тамганы уланд дөрвөлжин үсгийн эвхмэл тигээр, хятад хэлээр “Сангийн явдлын яамны эрхэлсэн түшмэлийн тамга” гэж бичсэн. Тамганы орой дээр, бариулын хоёр талаар тухайн үеийн ёс уламжлалын дагуу хэзээ, хаана хийснийг бичсэн. Тэнд “Сюаньгуаны 2-р оны 3 сарын өдөр” гэсэн үг байгаагаас үзэхэд уг тамгыг 1371-1372 оны орчим үйлдсэн нь тодорхой мэдэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, энэ тамгыг үйлдсэн цаг үе нь Хархорум хотод Монголын хаан ширээнд суусан Юань гүрний сүүлчийн хааныг залгамжлагч Аюуширидаара буюу Билэгт хааны үед холбогдох нь тодорхой болсон билээ (Эрдэнэбат 2002: 49-57).

Японы Такашима арлын орчим далайн гүнд хийсэн малтлагаас илэрсэн Юаний флотын олдворууд дунд Монголоос олддог, нүүдэлчдийн онцлогтой олдворууд ажиглагдаж байна. Хойшид Японы археологичдын судалгааны материалтай илүүхэн танилцаж, энэ чиглэлийн судалгааг үргэлжлүүлэн хийвэл сонирхолтой үр дүнд хүрч болно хэмээн найдаж байна.

Abstract

Comparison of some artifacts from the Yuan fleet found near Takashima island with artifacts from Kharakhorum and the Mongol burials

Ulambayar Erdenebat

In 1274 and 1281, the Mongol Yuan dynasty launched invasions against Japan, but their fleets were destroyed by typhoons. Hundreds of ships sent by Khubilai Khan sank in the waters near Takashima Island in Hakata Bay. Since the 1980s, Japanese archaeologists have been conducting systematic underwater archaeological research in the Takashima area. Their published research reports have uncovered numerous intriguing artifacts related to the Yuan fleet's historical invasions to Japan. Among these, several artifacts have been selected for this article to compare with 13th-14th century Mongolian burial artifacts. The findings reveal that the Yuan fleet's artifacts include a notable number of items characteristic of nomadic culture, such as belt and saddle decorations, horn leather punches, and hat ornaments, which are also commonly found in Mongolian burial sites.

Keywords: Mongol Empire, Yuan dynasty, Khubilai Khan, Mongol invasion of Japan, Takashima, Kharakhorum, Mongol burial artifacts

Ном зүй

Амартүвшин, Ч., Лхүндэв, Г., Галдан, Г. (2010). Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь “Энержи Ресурс” ХХК-ны “Ухаа худаг” нүүрсний уурхай орчимд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. УБ.

Амартүвшин, Ч., Батболд, Н., Эрэгзэн, Г., Батдалай, Б. (2015). Чандмань Хар уулын археологийн дурсгал. УБ.

Амартүвшин, Ч., Батдалай, Б. (2020). Хагтын хадны оршуулга. “Нүүдэлчдийн өв судлал”. Tomus XXI-II, Fasc. 11: 110-127.

Киселев, С.В. (1965). Древнемонгольские города. Ответственный редактор С.В.Киселев. М.

Эрдэнэбат, У. (2002). Хар Хорум хотоос олдсон нэгэн тамганы тухай. “Шинжлэх Ухааны Академийн мэдээ”. №1, УБ: 49-57.

Эрдэнэбат, У. (2018). Монголын эртний нийслэл Хархорум. УБ.

Erdenebat, U. (2009). Altmongolisches Grabbrauchtum Archaeologisch-historische Untersuchungen zu den mongolischen Grabfunden des 11. bis 17. Jahrhunderts in der Mongolei. Teil 2: Katalog der Grabfunde. Inaugural-Dissertation zur Erlangung der Doktorwurde der Philosophischen Fakultät der Rheinischen Friedrich – Wilhelms Universität zu Bonn. Vorgelegt von Ulambayar Erdenebat aus Ulaanbaatar. Bonn (URN: urn:nbn:de:hbz:5-19581).

Ikeda, Yoshifumi (2011). Nagasaki ken Kita Matsuura gun Takashima shuhen kaitei ni nemuru gen kou kanren iseki ibutsu no haaku to kaimei (Kaitei bango 18102004). Heisei 18 nendo ~ Heisei 22 nendo kagaku kenkyu hi hojo kin kiban kenkyu (S) Kenkyu seika hokoku sho dai 3-satsu (Saishu hokoku sho). Нагасаки мужийн Кита Мацуура дүүргийн Такашима орчмын далайн гүнд буй Юань улсын довтолгоотой холбоотой олдворын судалгаа (Даалгаврын дугаар 18102004). 2006-2010 оны санхүүгийн жил. Шинжлэх ухааны судалгааны (S) үр дүнгийн тайлан. 3-р боть (Эцсийн тайлан). 2011 оны гуравдугаар сар (япон хэлээр).


Komaroff, L., Carboni, S. (2002). The Legacy of Genghis Khan: Courtly Art and Culture in Western Asia, 1256-1353. The Metropolitan Museum of Art, New York, Yale University Press, New Haven & London.

Matsuura (2011). Matsuura-shi bunkazai chosa hokukusho dai 4-shu Matsuurashi Takashima kaitei iseki soshuhen. Nagasaki ken Matsuura shikyoiku iinkai. Мацуура хотын соёлын өвийн судалгааны тайлан. 4-р боть: Мацуура хотын Такашима далайн гүнд буй олдворын судалгаа. Нагасаки мужийн Мацуура хотын боловсролын зөвлөл (япон хэлээр).

Torii Ryuzo (1942). Sculptured stone tombs of the Liao dynasty. Harvard Yenching Institute, Peking.

Zhao Feng, Jin Lin (2005). Gold, Silk, Blue and White Porcelain: Fascinating Art of Marco Polo Era. Edited by Zhao Feng and Jin Lin. Hangzhou.

Received: Oct. 10, 2024; Revised: Nov. 10, 2024; Accepted: Dec. 16, 2024




Зураг 1. Японы Такашима арлын орчмоос илэрсэн бүсний чимэглэл, хонх



Зураг 2. Монгол Улсын Дорноговь аймгийн Чандмань хар ууланд малтсан 13-14 дүгээр зууны монгол булинаас гарсан бүсний хүрэл чимэглэлүүд




Зураг 3. Улаанбаатар хотноо хувь хүний цуглуулганд байгаа 13-14 дүгээр зууны үеийн мөнгөн бүсний чимэглэлүүд



Зураг 4. Такашима арлын орчмоос илэрсэн бүсний чимэглэл, хонх



Зураг 5. Монгол Улсын Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Бухын хошуунаас олдсон 13-14 дүгээр зууны бүсний алт шармал зэс чимэглэлүүд






Зураг 6. Монгол Улсын Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгойн 9-р булинаас (2007 оны малтлага) олдсон 13-14 дүгээр зууны эмээлийн хавтас, зэс тоног



Зураг 7. Юань гүрний үеийн дурсгалд монгол морьтны хөмөлдөргийн хонх дүрсэлсэн нь



Зураг 8. Гөрөөлж яваа монголчууд. Арван зургаан хэсгээс бүрдсэн ширм хаалтны зургийн хэсэг. 17 дугаар зууны эхэн. Япон Улс, Токио, Идэмицу цуглуулга



Зураг 9. Такашима орчмоос олдсон худрага, хөмөлдрөгийн хөөмөл чимэглэл




Зураг 11. Улаанбаатар хотноо хувь хүний цуглуулганд байгаа 13-14 дүгээр зууны үеийн хударга хөмөлдрөгийн чимэглэл




Зураг 10. Лондон хотноо Насир Халилийн цуглуулганд байгаа, Монголын эзэнт гүрний үеийн монгол эмээлийн хударга хөмөлдрөгийн алтан чимэглэл



Зураг 12. Монголын эзэнт гүрний хүн чулуун хөрөгт дүрсэлсэн хавтага, хутга, шор.
а) БНХАУ, Өвөр Монгол, Юань улсын дээд нийслэл Шанду балгасын музей, б) Монгол Улс, Сүхбаатар, Онгон, Таван толгой



Зураг 13. Шор. а) Такашима орчмоос олдсон олдвор. б) Монголын Улсын Дорноговь аймгийн Чандмань Хар ууланд малтсан 13-14 дүгээр зууны монгол булшнаас олдсон мөнгөн бариултай эвэр шор



Зураг 14. Такашима орчмоос олдсон олдвор




Рис. 148. Кара-Корум. Резная из камня ручка к крышке сосуда.
1 — вид сверху; 2 — основание; 3, 6 — торцовые части; 4, 5 — стороны с изображениями.

Зураг 15а. Монголын эртний нийслэл Хархорум хотын малтлагаас олдсон олдворууд



Зураг 15b. Монголын эртний нийслэл Хархорум хотын малтлагаас олдсон олдворууд.
Монголын Үндэсний Музей, Улаанбаатар




Зураг 16a. БНХАУ-ын хувийн цуглуулагчид хадгалагдаж байгаа 13-14 дүгээр зууны монгол малгай ба хааш чулуун жинс



37 瓦楞帽
Walen Hat, braided of vine with animal hair
H22cm, Bottom width 23cm, Top width 8.5cm
私人收藏
Private collection

Зураг 16b. БНХАУ-ын хувийн цуглуулагчид хадгалагдаж байгаа 13-14 дүгээр зууны монгол малгай ба хааш чулуун жинс




Зураг 17. Такашима орчмоос далайгаас олдсон төмөр илд



Зураг 18. Монгол Улсын Баянхонгор аймгийн Арцат дэлийн хадны оршуулгаас олдсон модон хуйтай, төмөр илд




Зураг 19. Монголчууд Багдадыг эзэлсэн нь. Дийцийн цомог. 14 дүгээр зууны эхэн. Цаасан дээр усан будаг, алтаар зурсан. Берлин, Улсын Номын сан, Пруссийн соёлын өвийн сан, Дорно дахины тасаг



Зураг 20. Такашима орчмоос далайгаас олдсон нумын гичэр




Зураг 21. Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутаг Хагтын хадны оршуулгаас олдсон 13 дугаар зууны монгол цэргийн нум, саадаг



Зураг 22. Такашима орчмоос далайгаас олдсон багц сумнууд



Зураг 23. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Ухаа худаг гэдэг газар малтсан 13-14 дүгээр зууны монгол булинаас олдсон багц сумтай саадаг




Зураг 24. Самны олдворын жишээ. а) Такашима орчмоос олдсон олдвор. б) Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Гозгор толгой с) Дорноговь аймгийн Чандмань Хар уул






図版 25 管軍総把印



第 15 図 管軍総把印



第 16 図 管軍総把印（印影）

Зураг 25. Такашима арлын орчмоос далайгаас олдсон дөрвөлжин үсэгтэй тамга



Зураг 26. Хархорум хотын малтлагаас олдсон дөрвөлжин үсэгтэй тамга